

**“УЛААНБААТАР БАРИЛГА – 2023” ОЛОН УЛСЫН ҮЗЭСГЭЛЭН
ЯАРМАГИЙН ХҮРЭЭНД ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН
НЭГЖҮҮДЭЭС “ШИЛДЭГ” ШАЛГАРУУЛАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ**

Зорилго:

Монголын барилгын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага аж ахуй нэгжүүдээс шилдэг орон сууц бүтээн байгуулсан, шинэ дэвшилтэт материал бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, шинэ технологи нэвтрүүлсэн болон зах зээлд нийлүүлсэн байгууллага, аж ахуйн нэгжийн ажлын амжилтыг үнэлж урамшуулах, туршлагыг нь дэлгэрүүлэн, зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд энэхүү арга хэмжээний зорилго оршино.

Номинациуд:

1. Дэвшилтэт шинэ техник, технологийг зах зээлд нэвтрүүлэгч,
2. Барилгын материалын шилдэг үйлдвэрлэгч,
3. Шилдэг орон сууц- Барилга угсралтын байгууллага,

Тусгай шагнал:

4. Үзэсгэлэнгийн шилдэг тохижилттой байгууллага,
5. Байгаль орчинд ээлтэй ногоон технологийг дэмжигч байгууллага,

Тавигдах шаардлага, нөхцөл:

1. Энэхүү шалгаруулалтанд үзэсгэлэнд оролцогч өмчийн бүх хэлбэрийн байгууллага, аж ахуй нэгжүүд хамрагдана.
2. Тавигдах шаардлага:
 - Байгууллагын танилцуулга,
 - Байгууллагын гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн хуулбар,
 - Хийж гүйцэтгэсэн угсралтын ажил, ашиглалтанд оруулсан барилга, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо, хэмжээ,
 - Үйлдвэрлэл-технологийн талаар шинээр хийсэн ажил, хөрөнгө оруулалтын хэмжээ, Шинэ, техник технологи, дэвшилтэт материал хэрэглэсэн /ашигласан/ тухай мэдээлэл, танилцуулга,

- Шинээр ажлын байр бий болгосон байдал,
- Захиалагч /хэрэглэгч/, Улсын мэргэжлийн хяналтын болон хэрэглэгчдийн эрх ашиг хамгаалах байгууллагын тодорхойлолт,
- Мэргэжлийн байгууллагын болон сорилтын лабораторийн дүгнэлт, тухайн бүтээгдэхүүн нь үндэсний болон олон улсын стандарттай, Тохирлын гэрчилгээтэй эсэх мэдээлэл,
- Барилга угсралтын байгууллага нь MNS 6058:2009 “Орон сууцны барилгын доторх сууцны талбай тооцох аргачлал” стандартын мөрдөлтийн байдал, энэ талаар хэрэглэгчдээс санал гомдол гарсан талаархи мэдээлэл,

Шалгаруулалтын хугацаа :

- Материал бүрдүүлэн ирүүлэх байгууллагууд 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 15 цаг, 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 15 цагт тус тус шалгаруулалтын комисст ирүүлсэн байна. /Мишээл экспо төвийн Маркетинг, Бизнес хөгжлийн албаны Үзэсгэлэн хариуцсан ахлах менежер З. Одонтуяа-д битүүмжлэн хүргүүлэх/
- Хугацаа хоцорч ирүүлсэн материалыг шалгаруулалтанд оролцуулахгүй болно.

Сонгон шалгаруулалтыг зохион байгуулагчид:

- Шалгаруулалтын комисс

Жич:

- Оролцогч байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээ, барилгын чанарын талаар олон нийтээс санал асуулга авна,
- Хэрэглэгчийн таашаалд нийцсэн бүтээгдэхүүн /сайн маркетингтэй, сурталчилгаа, үзүүлэх таниулах/

“Мишээл Экспо” ХХК

2022 оны 11 дүгээр сарын 16